# Орон цагийн дарааллаар өрнүүлэн учир шалтгааны уялдаа холбоотой бичих

# Алхам 1: Сэдэв сонгоё

## Дараах үйлийн алхмыг баримтална.

1. Бичих сэдэв сонгох
2. Мэдээллийн эх сурвалжаа сонгох
3. Цуглуулсан мэдээллийг бүлэглэх
4. Намтар бичих төлөвлөгөө гаргах
5. Ноороглон бичих
6. Сайжруулан бичих

# Миний ээж

Монголын үзэсгэлэнт сарангоо намайг төрүүлсэн эжий
Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн эжий
Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн эжий
Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн эжий
гэж хэн шүлэглэсэн бэ?





| | |
|---|---|
| 1906 | Төрсөн. |
| Багадаа | Гэрийн боловсрол эзэмшсэн. |
| 1921-1924 | Цэргийн Яаманд бичээч, нарийн бичгийн дарга |
| 1925 | Бүх Монголын пионерийн товчооны дарга |
| 1925-1926 | ЗХУ-ын Ленинград хотод Улс төрийн академийн сонсогч |
| 1926-1929 | Германы Берлин, Лейпциг хотод оюутан |
| 1929-1930 | Төмрийн үйлдвэрт орчуулагч, |
| 1930-1934 | “Залуучуудын үнэн” сонинд утга зохиолын ажилтан |
| 1931-1934 | Шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан |
| 1934-1936 | Мөн хүрээлэнд түүхийн ба дуун ухааны тасгийн эрхлэгч |
| 1937 | Төв театрт мэргэжлийн зохиолч |
| 1937 | Таалал төгссөн. |

Д.Нацагдорж ЗХУ, Герман улсад хэдэн жил суралцаж, өрнөдийн соёлын шилдэг өв сантай гүнзгий танилцжээ.

**Уран бүтээл**

- “Ушаандар”, “Сандо амбаны харгис явдал” жүжиг,
- “Учиртай гурван толгой” дуурь,
- “Миний нутаг”, “Од”, “Октябрь” зэрэг олон арван шүлэг,
- “Хуучин хүү”, “Цагаан сар ба хар нулимс”, “Харанхуй хад”

## Д.Нацагдоржийн намтрын товчооныг уншаарай.

- Намтар- Хүний төрсөн цагаас хойших амьдрал ахуй, ажил төрөл, бүтээл туурвил, амжилт, гавьяа шагналыг цагийн дараалаар тодорхойлж бичсэн түүх

**2018 оны сурах бичиг 97-р тал**
**2019 оны сурах бичиг 97-р тал**

**Алхам 2: Мэдээлэл хайж, материал цуглуулъя.**

# Мэдээллийн эх сурвалжийг мэдэж аваарай.

1. Намтрыг нь бичих хүнээ сонгох: Д.Нацагдорж

2. Мэдээллийн эх сурвалжаа сонгож, хайх















# Мэдээлэл тус бүрд юуны тухай өгүүлснийг тодорхойлоорой.

1. Бага насандаа бичиг үсэгт суралцсан.

2. Гүн Галуутай гэдэг газар ядуу тайжийн гэр бүлд төржээ. Долоон настай байхад нь эх Цоомойн Пагма нь бие баржээ. Тэрээр эцэг Дашдоржийн ивгээлд өсөж өндийжээ.

3. ЗХУ-ын Ленинград хотноо Улс төрийн академид 1925-1926 онд суралцав.
1926-1929 онд Берлин, Лейпциг хотуудад хэл бичиг, сонин, сэтгүүл, дорно дахин, ерөнхий эрдэмд суралцсан.
1929-1930 онд төмрийн үйлдвэрт орчуулагч

4. 1937 онд таалал төгссөн.

5. 1906 онд Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт төрсөн.

6. Түүний бүтээлүүд "Учиртай гурван толгой"-1934 онд, Зохиолын түүвэр-1955 онд, алдарт "Миний нутаг"-1963 онд, Ламбагуайн нулимс-1976 онд хэвлэгдэж байжээ.

7. 1924 онд 18 настай Д.Нацагдорж Улсын Анхдугаар Их Хурлын зохион байгуулалтын ажилд оролцож байжээ.

8. 1921-1924 онд цэргийн яаманд бичээч
1925 онд Монголын пионерийн байгууллагын дарга
1925 оноос Бүх Монголын пионерийн товчооны дарга хийж байсан.
ЗХУ-ын Ленинград хотноо Улс төрийн академид 1925-1926 онд суралцав.

9. 1930-1934 онд Залуучуудын үнэн сонинд утга зохиолын ажилтан
1931-1934 шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан
1934-1936 ШУ-ны хүрээлэнд тасгийн эрхлэгч
1937 онд Төв театрт мэргэжлийн зохиолч

10. "Ушаандар", "Сандо амбаны харгис явдал" жүжиг "Учиртай 3 толгой" дуурь, "Миний нутаг", "Од", "Октябрь" зэрэг олон арван шүлэг“, “Хуучин хүү", "Цагаан сар ба хар нулимс", "Харанхуй хад"зэрэг өгүүллэгүүдээрээ алдаршжээ.

**Алхам 3: Цуглуулсан мэдээллээ бүлэглэе.**

# Цуглуулсан мэдээллийг бүлэглээрэй.

| Баримтын дугаар | Баримт бүрд юуны тухай өгүүлсэн бэ? |
|---|---|
| 1. | Бичиг үсэгт суралцсан тухай |
| 2. | Гэр бүлийн тухай |
| 3. | |
| 4. | |
| 5. | |
| 6. | |
| 7. | |
| 8. | |
| 9. | |
| 10. | |

# Цуглуулсан мэдээллийг бүлэглээрэй.

| Баримтын дугаар | Баримт бүрд юуны тухай өгүүлсэн бэ? |
|---|---|
| 1. | Бичиг үсэгт суралцсан тухай |
| 2. | Гэр бүлийн тухай |
| 3. | Боловсрол эзэмшсэн тухай |
| 4. | Таалал төгссөн тухай |
| 5. | Төрсөн тухай |
| 6. | Уран бүтээлийн тухай |
| 7. | Олон нийтийн ажилд оролцсон тухай |
| 8. | Эрхэлсэн ажил, үүргийн тухай |
| 9. | Эрхэлсэн ажил, үүргийн тухай |
| 10. | Уран бүтээлийн тухай |

| Сэдэв | Баримтын дугаар |
|---|---|
| Бичиг үсэгт суралцсан тухай | 1 |
| Гэр бүлийн тухай | 2 |
| Боловсрол эзэмшсэн тухай | 3 |
| Таалал төгссөн тухай | 4 |
| Төрсөн тухай | 5 |
| Уран бүтээлийн тухай | 6, 10 |
| Эрхэлсэн ажил, үүргийн тухай | 7, 8, 9, |

# Алхам 4: Намтар бичих төлөвлөгөө гаргая

# Намтрын бүтцийг мэдэж аваарай.

- Эхлэл хэсэг
  - төрсөн тухай, бага нас
- Гол хэсэг
  - боловсрол, ажил үйлс, уран бүтээл
- Төгсгөл хэсэг
  - амьдралын сүүлийн мөч, бусдын үнэлэлт дүгнэлт, онцолж хэлсэн үг

# Намтрын бүтцийн дагуу материалаа байрлуулаарай.



# Намтрын бүтцийн дагуу материалаа байрлуулаарай.



# Алхам 5: Ноороглон бичье.

# 5. Нооргийн бичих

**Боловсрол**

ЗХУ-ын Ленинград хотноо Улс төрийн академид 1925-1926 онд суралцав. /суралцсаны дараа/

Д.Нацагдорж нь 1926-1929 онд Берлин, Лейпциг хотуудад суралцсан

**Ажил үйлс**

- 1921 онд хувьсгалт шинэ соёл урлагийн ажилд чармайн зүтгэж байв /байснаас гадна мөн ондоо/
- 1921 оноос Цэргийн яаманд бичээч, Цэргийн зөвлөлийн нарийн бичгийн дарга.
- 1924 онд 18 настай Д.Нацагдорж Улсын Анхдугаар Их Хурлын зохион байгуулалтын ажилд оролцож байжээ.
- 1925 оноос Бүх Монголын пионерийн товчооны дарга хийж байсан.
- 1929-1930 онд Төмрийн үйлдвэрт орчуулагч
- 1930-1934 онд Залуучуудын үнэн сонинд утга зохиолын ажилтан
- 1931-11934 шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан
- 1934-1936ШУ-ны хүрээлэнд тасгийн эрхлэгч
- 1937 онд Төв театрт мэргэжлийн зохиолч ...зэрэг ажлуудыг хийж байжээ.

Гол хэсэг

**Уран бүтээл**

- "Ушаандар", "Сандо амбаны харгис явдал" жүжиг,
- "Учиртай 3 толгой" дуурь,
- "Миний нутаг", "Од", "Октябрь" зэрэг олон арван шүлэг,
- "Хуучин хүү", "Цагаан сар ба хар нулимс", "Харанхуй хад" зэрэг өгүүллэгүүдээрээ алдаршжээ.

Гол хэсэг

- "Учиртай гурван толгой"-1934 онд,
- Зохиолын түүвэр-1955 онд,
- алдарт "Миний нутаг"-1963 онд,
- Ламбагуайн нулимс-1976 онд
- Шувуун саарал нэртэйгээр хэвлэгдэж байжээ

**Амьдралын сүүлийн он жил**

Төгсгөл хэсэг

1937 онд таалал төгсчээ.

**Алхам 6: Сайжруулж бичье.**

# Сайжруулан бичих аргыг ойлгоорой.

## Төрсөн тухай

1906 онд Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт төржээ.
Гүн Галуутай гэдэг газар ядуу тайжийн гэр бүлд төржээ.

Нацагдорж нь Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг Гүн Галуутай гэдэг газар ядуу тайжийн гэр бүлд төржээ.

## Бага нас

Долоон настай байхад нь эх Цоомойн Пагма нь бие баржээ.
Эцэг Дашдоржийн ивгээлд өсөж өндийжээ.
Бага насандаа гэрийн боловсрол эзэмшсэн.

Долоон настай байхад нь эх Цоомойн Пагма нь бие барсан тул эцэг Дашдоржийн ивгээлд өсөж өндийжээ.

# Сайжруулан бичээрэй

## Боловсрол

ЗХУ-ын Ленинград хотноо Улс төрийн академид 1925-1926 онд суралцав. /суралцсаны дараа/

Д.Нацагдорж нь 1926-1929 онд Берлин, Лейпциг хотуудад суралцсан

## Ажил үйлс

- 1921 онд хувьсгалт шинэ соёл урлагийн ажилд чармайн зүтгэж байв /байснаас гадна мөн ондоо/
- 1921 оноос Цэргийн яаманд бичээч, Цэргийн зөвлөлийн нарийн бичгийн дарга

# Сайжруулан бичээрэй

## Боловсрол

ЗХУ-ын Ленинград хотноо Улс төрийн академид 1925-1926 онд суралцав. /суралцсаны дараа/

Д.Нацагдорж нь 1926-1929 онд Берлин, Лейпциг хотуудад суралцсан

ЗХУ-ын Ленинград хотноо Улс төрийн академид 1925-1926 онд суралцсаны дараа1926-1929 онд Берлин, Лейпциг хотуудад суралцсан

## Ажил үйлс

- 1921 онд хувьсгалт шинэ соёл урлагийн ажилд чармайн зүтгэж байв /байснаас гадна мөн ондоо/
- 1921 оноос Цэргийн яаманд бичээч, Цэргийн зөвлөлийн нарийн бичгийн дарга

- 1921 онд хувьсгалт шинэ соёл урлагийн ажилд чармайн зүтгэж байснаас гадна мөн ондоо Цэргийн яаманд бичээч, Цэргийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байв.

# Гэрийн даалгавар

## Уран бүтээл



## Амьдралын сүүлийн он жил

